

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/11/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024.03.15	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: С.Цэвээнсүрэн Утас: 99441515 Цахим хаяг: Tseveensurens@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Материаллаг байдал	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал: Байхгүй	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 Албан шаардлага.....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



“ЦЭВЭР ХОТ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.БАЯСГАЛАН ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024. 03. 15 № 2/85

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Аудитаар илэрсэн зөрчил нь төлөвлөлтийн шатанд урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин болох 12,692.0 мянган төгрөгөөс хэтэрсэн бөгөөд бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд.

- Тайлант онд батлагдсан төсвөөс 102,265.1 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулж, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 49,161.8 мянга, ХХОАТ-ын өглөг 20,179.2 мянга, шатахууны өглөг 32,464.1 мянган төгрөгийг шилжүүлээгүйгээс өр төлбөр үүссэн байна.
- 2018 онд үүссэн НӨАТ-ын авлага 2,534.6 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ”, 20.2.7 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих”, мөн санхүүгийн тайлангийн

5020322

“Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тус байгууллага нь тайлант онд нийт 770,800.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд гэр хорооллын 8180 айл өрх, орон сууцны 1898 айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгж 350 байгууллагын хог хаягдлыг тээвэрлэж, 52 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 85.88 хувьтай дүгнэсэн байна.

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke extending to the right. The signature is written over a faint red rectangular stamp.

Б.МӨНХБАТ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,840,216.77</u>	<u>53,090,561.56</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	602,922.10	30,200.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	602,922.10	30,200.39
3121	Төгрөг	602,922.10	30,200.39
31213	Арилжааны банк дахь харилцах	602,922.10	30,200.39
33	АВЛАГА	2,534,590.16	2,534,590.16
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,080,000.00	1,080,000.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,454,590.16	1,454,590.16
35	БАРАА МАТЕРИАЛ	55,702,704.51	50,525,771.01
354	Хангамжийн материал	54,322,704.51	49,145,771.01
35410	Бичиг хэргийн материал	708,120.00	884,680.00
35420	Аж ахуйн материал	47,892,154.51	45,962,251.01
35430	Сэлбэг хэрэгсэл	5,722,430.00	2,298,840.00
35600	Мал амьтад	1,380,000.00	1,380,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>577,200,347.73</u>	<u>515,650,083.41</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	577,200,347.73	515,650,083.41
391	Үндсэн хөрөнгө	577,200,347.73	515,650,083.41
392	Биет хөрөнгө	538,980,347.73	477,430,083.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,220,049.00	17,220,049.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,610,024.50	-10,332,029.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	737,157,000.00	717,740,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 415,294,916.67	-429,241,138.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,386,000.00	8,054,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,493,611.11	-3,995,777.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,147,800.00	11,112,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,448,800.00	-8,211,633.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	200,116,851.00	219,116,851.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,200,000.00	-44,033,370.20
393	Биет бус хөрөнгө	38,220,000.00	38,220,000.00
39301	Програм хангамж	869,000.00	869,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-869,000.00	-869,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	38,220,000.00	38,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>636,040,564.50</u>	<u>568,740,644.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>39,008,447.10</u>	<u>102,265,073.16</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	39,008,447.10	102,265,073.16
413	Өглөг	39,008,447.10	102,265,073.16
4136	Бусад өглөг	39,008,447.10	102,265,073.16
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	5,080,699.24	20,179,176.81
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	13,832,137.20	49,161,834.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	20,095,610.66	32,924,062.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>597,032,117.40</u>	<u>466,475,571.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	597,032,117.40	466,475,571.81

Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	612,440,438.00	612,440,438.00
51101	Өмч: - төрийн	612,440,438.00	612,440,438.00
512	Хуримтлагдсан үр дүн	-15,408,320.60	-145,964,866.19
51210	Өмнөх үеийн үр дүн	-369,124,148.93	-15,408,320.60
51220	Тайлант үеийн үр дүн	353,715,828.33	-130,556,545.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>636,040,564.50</u>	<u>568,740,644.97</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,199,850,991.00	860,641,183.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,199,850,991.00	860,641,183.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,199,850,991.00	860,641,183.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,199,850,991.00	860,641,183.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	777,714,140.00	860,641,183.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	422,136,851.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	846,135,162.67	991,197,728.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	846,135,162.67	991,197,728.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	846,135,162.67	991,197,728.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	846,135,162.67	991,197,728.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	813,537,546.66	895,064,131.27
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,597,616.01	96,133,597.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>353,715,828.33</u>	<u>-130,556,545.5</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>353,715,828.33</u>	<u>-130,556,545.5</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>777,714,140.00</u>	<u>820,170,850.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	777,714,140.00	820,170,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	777,714,140.00	820,170,850.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	777,714,140.00	820,170,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	717,950,000.00	778,800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,764,140.00	41,370,850.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	790,436,012.66	816,743,571.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	790,436,012.66	816,743,571.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	790,436,012.66	816,743,571.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	790,436,012.66	816,743,571.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	790,436,012.66	816,743,571.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(12,721,872.66)	3,427,278.29
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,223,000.00	4,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,223,000.00	4,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,223,000.00	4,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,223,000.00	4,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,223,000.00)	(4,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(21,944,872.66)	(572,721.71)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,547,794.76	602,922.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	602,922.10	30,200.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	612,440,438.00		-369,124,148.93	243,316,289.07
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,440,438.00	0.00	-369,124,148.93	243,316,289.07
4	Тайлант үеийн үр дүн			353,715,828.33	353,715,828.33
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,440,438.00	0.00	-15,408,320.60	597,032,117.40
6	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	612,440,438.00	0.00	-15,408,320.60	597,032,117.40
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,440,438.00	0.00	-15,408,320.60	597,032,117.40
8	Тайлант үеийн үр дүн	0.00		-130,556,545.59	-130,556,545.59
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,440,438.00	0.00	-145,964,866.19	466,475,571.81

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/Д	Зардал	2023 он		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		30,200.39		
2	УРСГАЛ ЗАРДАЛ	778,800,000.00	801,575,341.70	(22,775,341.70)	102.92
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	773,540,000.00	798,175,341.70	(24,635,341.70)	103.18
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444,476,100.00	344,818,680.70	99,657,419.30	77.58
5	Үндсэн цалин	444,476,100.00	344,818,680.70	99,657,419.30	77.58
7	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,049,000.00	67,000,000.00	28,049,000.00	70.49
8	Тэтгэврийн даатгал	95,049,000.00	67,000,000.00	28,049,000.00	70.49
9	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,767,000.00	8,272,568.00	1,494,432.00	84.70
10	Гэрэл, цахилгаан	1,963,000.00	2,967,568.00	(1,004,568.00)	151.18
11	Түлш, халаалт	2,920,000.00	445,000.00	2,475,000.00	15.24
12	Цэвэр, бохир ус	264,000.00	-	264,000.00	0.00
13	Байрны түрээс	4,620,000.00	4,860,000.00	(240,000.00)	105.19
14	Хангамж, бараа материалын зардал	143,018,900.00	255,518,579.00	(112,499,679.00)	178.66
15	Бичиг хэрэг	3,229,200.00	2,820,200.00	409,000.00	87.33
16	Тээвэр, шатахуун	134,825,300.00	249,918,629.00	(115,093,329.00)	185.36
17	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,372,800.00	1,307,650.00	65,150.00	95.25
18	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,591,600.00	1,472,100.00	2,119,500.00	40.99
19	Нормативт зардал	6,808,000.00	2,290,400.00	4,517,600.00	33.64
20	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,808,000.00	2,290,400.00	4,517,600.00	33.64
21	Эд хогшил, урсгал засварын зардал	52,438,000.00	65,740,750.00	(13,302,750.00)	125.37
22	Багаж, техник, хэрэгсэл	6,450,000.00	6,477,300.00	(27,300.00)	100.42
23	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,988,000.00	13,590,800.00	5,397,200.00	71.58
24	Урсгал засвар	27,000,000.00	45,672,650.00	(18,672,650.00)	169.16
25	ТУЗ-н зардал	2,800,000.00	-	2800000.00	0.00
26	ТУЗ-н зардал	2,800,000.00	-	2,800,000.00	0.00
27	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,183,000.00	4,778,864.00	4,404,136.00	52.04
29	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	350,000.00	300,000.00	53.85
30	Даатгалын үйлчилгээ	1,105,000.00	929,250.00	175,750.00	84.10
31	Тээврийн хэрэгслийн татвар	2,328,000.00	1,644,764.00	683,236.00	70.65
33	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,100,000.00	1,854,850.00	3,245,150.00	36.37
34	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	49,755,500.00	(39,755,500.00)	497.56
35	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	47,755,500.00	(39,755,500.00)	596.94
36	Гэрээт зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
37	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,260,000.00	3,400,000.00	1,860,000.00	64.64
38	Бусад урсгал шилжүүлэг	5,260,000.00	3,400,000.00	1,860,000.00	64.64

39	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,260,000.00	3,400,000.00	1,860,000.00	64.64
40	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	120,000,000.00	125,200,000.00	(5,200,000.00)	104.33
41	Орон нутгийн төсвөөс	120,000,000.00	125,200,000.00	(5,200,000.00)	104.33
43	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	620,200,000.00	653,600,000.00	(33,400,000.00)	105.39
44	Санхүүгийн дэмжлэг	620,200,000.00	653,600,000.00	(33,400,000.00)	105.39

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын зорилго нь "Аюулгүй ажиллагааг эрхэмлэн, ард түмний итгэл найдварыг алдахгүй, түргэн шуурхай үйлчилгээг ард түмэнд хүргэж ажиллах"-д оршино.

Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ нь 2023 онд менежментийн ерөнхий төлөвлөгөөг удирдлага болгон нийт нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлыг нэгдсэн цэгт төвлөрүүлэх, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хог хаягдлыг стандартын дагуу тээвэрлэх, цэвэр орчныг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна.

Мөн гэр хорооллын 8180 айл өрх, орон сууцны 1898 айл өрх, төрийн болон хувийн хэвшил аж ахуйн нэгж 350 байгууллага, иргэдийн хог хаягдлыг тээвэрлэж байна.

Тус байгууллага нь захиргаа аж ахуйн, тээвэр засвар үйлчилгээ, орон сууц гэсэн 3 нэгжтэй, 52 орон тоотой үйл ажиллагаа явуулсан бөгөөд 740,200.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант жил хөрөнгө зарцуулах нэгдүгээр гарын үсгийг захирал Ц.Баясгалан, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Л.Баттөмөр нар зурж, нярваар Г.Нацагюмсүрэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

"Цэвэр хот" ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй, санхүүгийн Leader-3, цалингийн Payroll программ ашигладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67,229.9 мянган төгрөг буюу 10,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,840.2	53,090.6	(5,749.7)
Мөнгөн хөрөнгө	602.9	30.2	(572.7)
Авлага	2,534.6	2,534.6	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	55,702.7	50,525.8	(5,176.9)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	577,200.3	515,650.1	(61,550.3)
Үндсэн хөрөнгө	1,015,116.7	1,012,333.0	(2,783.7)
Хуримтлагдсан элэгдэл	(437,916.4)	(496,682.9)	(58,766.6)
Нийт хөрөнгө	636,040.6	568,740.6	(67,299.9)
Өр төлбөр	39,008.4	102,265.1	63,256.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	597,032.1	466,475.6	(130,556.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	636,040.6	568,740.6	(67,299.9)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 30.2 мянган төгрөг болж 572.7 мянган төгрөгөөр буурсан байна. Тухайн байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь ХААН банкны 5249036765 тоот харилцах дансанд байршиж байна.

Татварын хэлтсээс авах 2018 онд үүссэн НӨАТ-ын 2,534.6 мянган төгрөгийн авлагыг татварын тооцоонд суутган тооцоо хийх албан бичгийг татварын хэлтэст явуулсан боловч тайлант онд шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу ирсэн тул авлагыг барагдуулаагүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 50,525.8 мянган төгрөг болж 5,176.9 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал 1,981.9 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 3,371.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой бөгөөд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн

327,395.7 мянган төгрөгийн бараа материалыг орлого авч, 331,192.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,012,333.0 мянган төгрөг болж 2,783.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 9/56 дугаар тогтоолоор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Автомашин ажилласан тос, маслыг цуглуулж хуримтлуулах цэг байгуулах" төслөөр 15,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 20 тоннын ёнкос үнэ төлбөргүй хүлээн авсан, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/65 дугаар тогтоолоор Баян-Овоо сумын Соёлын төвд ашиглаж байсан 15,583.3 мянган төгрөгийн үнэ бүхий автомашиныг балансаас балансад шилжүүлэн авсан, мөн төсвийн хөрөнгөөр 4,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий нохой устгалын буу худалдан авч, Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 14/28 тоот Хөрөнгө акталж, данснаас хасах тухай тогтоолоор 37,367.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 102,265.1 мянган төгрөг болж, 63,256.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 49,161.8 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 20,179.2 мянган төгрөг, шатахууны өглөг 32,646.1 мянган төгрөгийн өглөг байна. Өмнөх оны 39,008.4 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд барагдуулсан байна. Дээрх өр төлбөр нь шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор байгууллагын төсөвт хүндрэлтэй байдал үүсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 466,475.6 мянган төгрөг болж 130,556.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 130,556.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" үүрэгтэй.

Байгууллагын техник, эдийн засгийн гол үзүүлэлт нь Баянхонгор аймгийн хог хаягдлыг төвлөрсөн журмаар ачиж, тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулж ашиглахтай холбоотой иргэд, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэн хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулж, байгаль орчинд ээлтэй цэвэр орчныг бүрдүүлэх явдал юм.

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 8/49 тоот хуралдааны тогтоолоор тус байгууллагын 2023 оны хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг 620,200.0 мянган төгрөгөөр, орон нутгийн орлогоос 60,000.0 мянган төгрөгөөр, давсан орлого 60,000.0 мянган төгрөг, нийт 740,200.0 мянган төгрөгөөр баталсан.

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 11/68 тоот хуралдаанаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг 620,200.0 мянга, орон нутгийн орлогоос 60,000.0, давсан

орлогыг 30,600.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 90,600.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд тус байгууллага нь үйл ажиллагаанаас 130,556.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлагнд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Ц.Баясгалан танд танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны зардлын дүн 846,135.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,692.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,519.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага нь төрийн тусагй чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн байршуулж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, аудитаар 10,342.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 41,423.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 3,727.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	3,727.7	3	3,727.7	100%
Албан шаардлага	3	41,423.2	3	41,423.2	100%
Зөвлөмж	3	10,342.1	3	10,342.1	100%
Нийт дүн	9	55,493.0	9	55,493.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал: Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 105,799.7 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, 3 албан шаардлага өгсөн.

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант онд батлагдсан төсвөөс 102,265.1 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор шатахууны зардал 32,646.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 49,161.8 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 20,179.2 мянган төгрөгийг шилжүүлээгүйгээс өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг барагдуулж, цаашид өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 2018 онд үүссэн НӨАТ-ын авлага 2,534,6 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх авлагыг тайлант онд үүссэн ХХОАТ-ын өглөгөөс суутган тооцож барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.1.3 2023 оны 7 дугаар сард 1 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэл 1,000.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын мэдээнд мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд батлагдсан төсвөөс 102,265.1 мянган төгрөгийг хэртүүлэн зарцуулж, НДШ-ийн өглөг 49,161.8 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг	1	102,265.1			1	102,265.1		

Баянхонгор аймгийн "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

20,179.2 мянган төгрөг, шатахууны өглөг 32,646.1 мянган төгрөгийн өглөг тус тус үүссэн байна.							
2018 онд үүссэн Татварын хэлтсээс авах НӨАТ-ийн авлага 2,534.6 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.	1	2,534.6			1	2,534.6	
2023 оны 7 дугаар сард 1 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэл 1,000.0 мянган төгрөгийг мэдээлээгүй орхигдуулсан байна.	1	1,000.0			1	1,000.0	
Нийт дүн	3	105,799.7			3	105,799.7	

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 236/А0571212/БНА-2024/11/ Номгон
НА-СТА-ОНА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд батлагдсан төсвөөс 102,265,073 (Нэг зуун хоёр сая хоёр зуун жаран таван мянга далан гурван төгрөг)-ийг хэтрүүлэн зарцуулж, шатахууны өглөг 32,646,062 (Гучин хоёр сая зургаан зуун дөчин зургаан мянга жаран хоёр төгрөг)-өөр, НДШ-ийн өглөг 49,161,834 (Дөчин есөн сая нэг зуун жаран нэгэн мянга найман зуун гучин дөрвөн төгрөг)-өөр, ХХОАТ-ын өглөг 20,179,176 (Хорин сая нэг зуун далан есөн мянга нэг зуун далан зургаан төгрөг)-өөр тус тус үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


Өр төлбөрийг барагдуулж, хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5040716

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын дарга Ц.Баясгалан, нягтлан бодогч Л.Баттөмөр нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ
АУДИТОР:  С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 224/А059/212/БНА-2024/11/ Номгон
НА-СТА-ОНА

Г

Г

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2018 онд үүссэн НӨАТ-ын авлага 2,534,590 (Хоёр сая таван зуун гучин дөрвөн мянга таван зуун ерэн төгрөг)-ийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.



Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Өр төлбөрийг тайлант онд үүссэн ХХОАТ-ын өглөгөөс суутган тооцож барагдуулах, хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5040676

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын дарга Ц.Баясгалан, нягтлан бодогч Л.Баттөмөр нарт даалгав^{1, 2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ
АУДИТОР:  С.ЦЭВЭЭНСҮРЭН

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 225/А0571212/БНА-2024/11/
НА-СТА-ОНА

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2023 оны 7 дугаар сард 1 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэл 1,000,000 (Нэг сая төгрөг)-ийг нийгмийн даатгалын мэдээнд мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь “Ерөнхий нягтлан бодогч нь аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих” заалтыг зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5040679

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын дарга Ц.Баясгалан, нягтлан бодогч Л.Баттөмөр нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:  С.ЦЭВЭЭНСҮРЭН

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно